

**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2017 оны 11 сарын 13-ны байдлаар

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Удирдлага зохион байгуулалт, авлигатай тэмцэх санал, санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх чиглэлээр:				
1	Авлигын эсрэг үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх хэрэгжилтэнд хяналт тавих, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд ОӨУБЕГ, Аймгийн ЗДТГ-т хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон эхний хагас жил болон 9 сарын биелэлтийг холбогдох дээд газруудад хүргүүлсэн.	100%
2	Төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх	Төрийн албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, шударга байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Төрийн албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар Прокурорын байгууллагаас 1, ТББ-2 удаагийн сургалт, холбогдох тараах материалыг аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс авч ажиллаж байна.	100%
		Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин зөрчил гаргуулахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах	1. Үйлчилгээний танхим, архив болон албан хаагчдын өрөө тасалгаанд 10 камер суурилуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж хэвшсэн. 2. Байгууллагын үйлчилгээний стандарт, улсын бүртгэлийн ажилтаны ёс зүйн дүрмийг үйлчилгээний танхимд бүртгэгч нарт ил харагдахуйц байрлуулж, хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 3. Албан хаагчдын ажлын цагийн ирц бүртгэл, цагийн нягтрал, хурууны хээний цахим төхөөрөмж, бүртгэлийн дэвтрээр давхар бүртгэж, ОӨУБЕГ-ын Тамгын газартай Able программаар нэгдсэн сүлжээнд холбогдон хяналт тавин ажиллаж байна.	100%

			<p>4. Ажлын цаг ашиглалтанд тогтмол хяналт тавьж, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагчдад ажлаас 1 өдрийн чөлөө олгож байна.</p> <p>5. Байгууллагад нийт 8 нэгж, баг, комисс, зөвлөлийг томилон ажиллуулж байгууллагын дотоод үйл ажиллагаанд бүртгэгч нарыг бүрэн хамруулж, үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд тусган, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>6. Албан хаагчдын цалинг ажлын цаг ашиглалт, цахим бүртгэлийг үндэслэн олгож байна.</p>	
<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах чиглэлээр:</p>				
3	<p>Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах</p>	<p>Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах</p>	<p>Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг жил бүрийн 2-р сарын 15-ны дотор хуулийн хугацаанд ажилтнуудаас гаргуулан авч, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах, их хэмжээний өөрчлөлт гарсан 2 бүртгэгчээс хуулийн хугацаанд нь гаргуулан, баталгаажуулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулсан бөгөөд зөрчил гаргасан албан хаагчид бүртгэгдээгүй.</p>	100%
4	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах</p>	<p>Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг олон нийтэд мэдээлэх /цахимд хуудсанд байршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх г,м/</p>	<p>Улсын бүртгэлийн хэлтсийн 2017 онд хийх хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулан, байгууллагын цахим хуудас/or.burtgel.gov.mn/-д байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>“Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>Бүртгэлийн үйл ажиллагааны өдөр дутмын болон түүвэрчилсэн хяналтыг тухай бүр хийж, зааварчилгаа зөвлөгөө өгч хэвшсэн байна.</p> <p>Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг онлайн хэлбэрээр бүртгэн хуваарийн дагуу БХГ-ын байцаагчаар хянуулан ажиллаж байна.</p> <p>2017 оны 11 сарын 13-ны байдлаар 52 дүгнэлт үйлдэн, цахим хэлбэрээр бүртгэн баталгаажуулаад байна.</p>	100%

5	Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх -тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, / 1 сарын 10-ны дотор/, -хагас жилийн төсвийн гүйцэтгэл,/8 сарын 15-ны дотор/ өмнөх оны төсвийн гүйцэтгэл, /4-р сарын 25-ны дотор/, дараа жилийн төсвийн төсөл/9-р сарын 15-ны дотор/-ийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	<p><u>Мэдээллийн, санхүүгийн ил тод байдлын хүрээнд:</u></p> <p>-Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтүүдийг тухай бүр мэдээллийн самбарт болон http://shilendans.gov.mn/ цахим хуудаст байршуулж хэвшсэн байна.</p>	100%
		Төсвийн ерөнхийлөн захирагчийн /ОӨУБЕГ/төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4 сарын 25-ны дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 7 сарын 1-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах		100%
		Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх		
		-тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, -5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг		

		<p>-цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, -байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, - төсөв, өмч хөрөнгө, мөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 7 хоногийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлэх/шилэн дансны мэдээлэлд/ Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг, эхийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчилж байх</p>		
6	Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	Хуульд заагаагүй зөвшөөрөл, бүртгэл олгохгүй байх, тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалт, түүнийг олгоход шаардагдах баримт бичиг, шийдвэрлэх журмын талаарх мэдээллийг ил тод мэдээлэх/цахим болон самбар бусад хэлбэрээр/	<ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу тогтмол шуурхай хийж, бүртгэлтэй холбоотой бүх төрлийн гарын авлага, бүрдүүлэх материалын жагсаалтыг хэвлэн байгууллагын самбарт байрлуулснаас гадна иргэн хуулийн этгээдэд тараан өгч, шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүрт нь ханган ажиллаж байна. 2. Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүд болон шаардлагатай мэдээ, мэдээллийг ERDENET.MN цахим хуудсанд цаг тухайд нь байршуулан ажиллаж байна. 3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 01 сарын 29-ны өдөр батлагдснаар Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 5.4.1 дэх заалт хүчингүй болж, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон тусгай зөвшөөрлийг 2015 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн бүртгэхгүй болсон бөгөөд энэ талаар төрийн холбогдох байгууллагуудад мэдэгдэж, хуулийг сурталчлан ажиллаж байна. 	100%

		Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах /хууль тогтоомжид зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд/	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2009 оны 143-р тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, 2013 оны 412-р тогтоол “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” ХЗС-ын А/15 дугаар тушаал “Хууль зүйн салбарын нээлттэй бодлого”-ыг удирдлага болгон байгууллагын нээлттэй байдлыг ханган ажиллаж байгаа ба хууль журмын хүрээнд чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллаж байна.	100%
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	Шинээр ажилтан сонгон шалгаруулах ажлыг ил тод нээлттэй байдлыг хангах	Төрийн албаны зөвлөлөөс баталсан журам, зааврыг баримтлан ажилтан албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлбэрийг шалгаж, баяжилт тогтмол хийгддэг. Байгууллагын дотоод журманд заасны дагуу сул орон тоо гарсан тухай мэдээллийг ОӨУБЕГ-ын Төрийн албаны салбар зөвлөл, Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлэн ажилладаг. Энэ талаарх мэдээллийг ОӨУБЕГ-ын болон байгууллагын цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100%
8	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	Ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хамт олонд мэдээлэх	- УБЕГ-ын даргын 2009 оны 294 дүгээр тушаалаар батлагдаж, 2013 оны 492 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүртгэгч бүрийг үнэлэх үнэлгээний хуудсыг шинээр нэвтрүүлж, үйлчилгээний танхимын цонх бүр дээр бүрдүүлэх материалын жагсаалт гарган, дугаарлалтын системийг үйлчилгээний танхимд хэрэгжүүлж, үйлчилгээний танхимд “Угтах” үйлчилгээний зөвлөн туслах ажилтан шинээр авч ажиллуулж байгаа нь иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан, шат дамжлага, хүнд суртлыг багасгасан ач холбогдол бүхий үйл ажиллагаа болсон гэж дүгнэдэг. - ОӨУБЕГ-ын даргын 2016.11.21-ний өдрийн А/348 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн ажилтаны ёс зүйн дүрэм”-ийг нийт албан хаагчдад хэлтсийн шуурхай дээр танилцуулж, өдөр тутам дагаж мөрдүүлэхээр олшруулан тараан өгч, үйлчилгээний ажилтаны стандартын хэрэгжилтийг заалт тус бүрээр үнэлгээ өгөн дүгнэж, үүрэг даалгавар чиглэл өгч, ажилтнаар гарын үсэг зуруулан баталгаажуулсан.	100%

		<p>Ёс зүйн дүрмийн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх/ёс зүйн хороо</p>	<p>- ОӨУБЕГ-ын даргын А/348 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 5.4, 5.5-ийг үндэслэн Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ёс зүйн салбар хороог 2017.03.14-ны өдөр хамт олны санал хураалтаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан, нэр бүхий 6 бүртгэгчийг ёс зүйн хороогоор авч хэлэлцэн тэмдэглэл хөтлөн сануулахаар арга хэмжээ авсан байна. “Улсын бүртгэлийн ажилтаны ёс зүйн дүрэм”-ийг дүрмийн хүрээнд чанд мөрдүүлэхээр албан хаагчдад шаардлага тавин ажиллаж байна. - Үйлчилгээний танхимд 70358989 утсаар иргэдийн санал, хүсэлт, гомдлыг бүртгэлийн дэвтэрт хүлээн авч зөвлөгөө өгөн, тухай бүр нь холбогдох хариуг өгч байна.</p>	100%
		<p>Зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, зөрчил үүссэн нөхцөлд хариуцлага хүлээлгэх</p>	<p>- Камерын хяналтыг байнга тавьж, ажиллахгүй доголдох тухай бүр мэдээлэл технологийн ажилтанаар хэвийн үйл ажиллагааг хангуулан ажиллаж байна. - Албан хаагчдыг үнэлэх, урамшуулах системийг улам боловсронгуй болгох тухай Ерөнхий газраас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхэд чиглэгдэж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: Бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, чирэгдэлгүй, шуурхай хүртээмжтэй, үйлчилгээний соёл, ёс зүйтэй байж иргэдэд үйлчлэх зорилгоор үйлчилгээний заалны цонх бүр дээр үйлчилгээний үнэлгээний хуудас ажиллуулж, үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн сэтгэл ханамжийг иргэдэд ил тод, нээлттэй байдлаар үнэлүүлэн сард 1 удаа үнэлгээг дүгнэн үзэхэд нийт хамрагдсан 11 улсын бүртгэгчээс 27 хувь нь хангалтгүй үнэлгээ авсан байна. Удаа дараа хангалтгүй үнэлгээ авсан ажилтан, албан хаагчдад хамт олны дунд сануулга өгч, анхааруулга өгч, илэрсэн зөрчил дутагдалд чиглэл, зөвлөмж өгч ажиллаж байна.</p>	100%
Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн		<p>Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх цахим системийн үйл ажиллагааг сайжруулан бүх төрийн байгууллагуудад</p>	<p>Иргэдийн өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авах албан хаагчийн нэр, албан тушаал, утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн</p>	

9	авах, шийдвэрлэх, шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах, хариу өгөх үйл ажиллагааг боловсронгуй болгох	нэвтрүүлэх, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх дундаж хугацааг өнөөгийн түвшнээс бууруулах	шийдвэрлэлтийн мэдээ, тайланг сар, улирлаар гарган аймгийн ЗДТГ болон ОӨУБЕГ-т тогтмол хүргүүлэн ажилладаг. 2017 оны 10 сарын 25-ны байдлаар манай байгууллагад нийт 26 өргөдөл, гомдол ирсэнээс цахим-1, бичгээр-15, утсаар-10, үүнээс /70353511 төв/-8, /ЗГ-ын 11-11/-2 өргөдөл ирсэн. Эд хөрөнгийн тасагт-9, иргэний бүртгэлийн тасагт-4, бусад-13, шийдвэрлэлт 100 % байна.	100%
		Өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлж, шуурхай шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авч ажиллах	Иргэдийн өргөдлийг байгууллагын цахим хуудсаар хүлээн авч, хариуг цахимаар өгөх, ажлыг амжилттай эхлүүлээд байна.	100%
		Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шийдвэрлэлтийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлж хэвших	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг байгууллагын цахим,/erdenet.mn/ аймгийн ЗДТГ, ОӨУБЕГ-т тогтмол хуулийн хугацаанд хүргүүлж, мэдээллийг байгууллагын цахим хуудас болон erdenet.mn тогтмол байршуулж байна.	100%
10	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх	- Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэл, иргэний бүртгэл, гадаад паспортын бүртгэгч нарыг Үйлчилгээний танхимын тал бүрээс нь хянах боломжтойгоор 5 камер суурилуулан, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна.	100%
		Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх/ажлын байрыг сэлгүүлэх	Эд хөрөнгийн бүртгэгчдийг эд хөрөнгийн бүртгэлийн шат дамжлагыг өөрчилж бүртгэл хүлээн авах, сканердах, боловсруулж бүртгэх шат дамжлагатай болголоо. Мөн /иргэн, эд хөрөнгө/-ийн бүртгэгчдийн хариуцан ажиллах баг, ажил үүргийн хуваарийг улирал бүр өөрчилж, сэлгэн ажиллуулж байна. Албан хаагчдын өрөөний хаалга, үйлчилгээний танхимын цонх бүрт авлигаас урьдчилсан сэргийлэх наалт бүхий тэмдэглэгээг байршуулсан.	100%

		Төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлэх	Эд хөрөнгийн эрхийн бүртгэл цахим хэлбэрт бүрэн шилжсэн, иргэний бүртгэлийн лавлагааны үйлчилгээг төрийн үйлчилгээний цахим машинаас авч байгаа нь хүнд суртал, чирэгдлийг багасгасан түргэн шуурхай иргэдэд хүрсэн үйлчилгээ болж байна. Цаашид иргэний бүртгэл, хуулийн этгээдийг бүрэн цахимжуулах ажил хийгдэнэ. Энэхүү ажлын чиглэлээр бэлтгэл ажлын хүрээнд цаасан баримтыг цэгцлүүлэхээр 2 гэрээт ажилтны орон тоо, цалингийн санг байгуулан ажиллаж байна	100%
--	--	--	---	------

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС